

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРТ

Тодруулгын хариу

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-д Дугуй нийлүүлэгчийг сонгох ЭТТ/201901244 дугаартай, З багцтай тендер шалгаруулалт 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр цахимаар зарлагдсан. "Алтанжин Чоян" ХХК-иас 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн № 2019/35 тоот албан бичгээр тус тендер шалгаруулалттай холбоотой тодруулга ируулсэн байна. Үүнд

...Нийлүүлэх бараа нь Япон, Солонгос, АНУ-ын сайн чанарын брэнд байна. Мөн Багц 2-т COOPER, TOYO брэндтэй дүйцэх, Багц 3-т BRIDGESTONE брэндтэй дүйцэх гэж заасан нь өрсөлдөх тэгш боломжийг хаасан ба зөвхөн тус брэндийн гэрээт борлуулагч оролцохыг зөвшөөрсөн гэсэн утгаар ойлгогдож байна. Энэ нь бусад улсын дугуй үйлдвэрлэгч компаниудын тендерт оролцох боломжийг хаасан заалт гэж ойлгож байна гэжээ.

1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.1.4-т Барааны тэмдэг, нэр, хэлбэр МАЯГ, төрүү, тарал, үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайллан заах шаардлагатай бол түүний ард "эсхүл" түүнтэй дүйцэх гэсэн тодотгол хэрэглэнэ гэсэн байна.

2. Бараа нийлүүлэх тендерийн жишиг бичиг баримтын 19.1/г/-д "...Захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч тайлбар ируулнэ..."

3. Бараа нийлүүлэх тендерийн жишиг бичиг баримтын 19.1/в/-д "...Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл ирүүлнэ. Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасан гай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна..." гэсэн байна.

Иймд төнүүрнийн баримт бичгийн холбогдох хууль, журамын дагуу боловоруулсан бэгээд компаниудын төндөрт оролцох боломжийг хязгаарласан заалт байхгүй болно.

Үнэлгээний хорооны дарга

Т.Золжаргал